

**"ХИШИГ-УУЛ" ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл**

2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр

Улаанбаатар хот

"Хишиг-Уул" ХК ("Компани" гэх)-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улс, Улаанбаатар хот, Улсын Их Дэлгүүрийн 7 давхрын ресторан VIP өрөөд 16:00 минутад эхлэв.

Тооллогын комисс ирцийн мэдээллийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 700,607 ширхэг хувьцаа эзэмшдэг нийт хувьцааны 80,6%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Я.Нэргүй, Ц.Роза биеэр, 37,130 ширхэг хувьцаа эзэмшдэг нийт хувьцааны 4,3%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Г.Байгалмааг итгэмжлэлээр төлөөлж Я.Нэргүй төлөөлж оролцож байгаа бөгөөд нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 737,737 ширхэг хувьцаа буюу 84,9%-ийн ирцтэйгээр оролцож байгаа болохыг мэдэгдэж байна. Ийнхүү Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурал хүчин төгөлдөр ирцтэй эхэлж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулж, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлав. Хэлэлцэх асуудлын жагсаалт:

Нэг. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2026 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;

Хурлын дарга Я.Нэргүй: Хэлэлцэх асуудлын нэг болон хоёрдугаар асуудал болох Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт болон компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг дэлгэрэнгүй танилцуулга хийв. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт санал, тодруулах асуудал байна уу?

Хувьцаа эзэмшигч, компанийн дэд захирал Ц.Роза: Санал байхгүй, дэмжиж байна.

Гуравдугаар асуудал: Компанийн 2026 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

Хувьцаа эзэмшигч, компанийн дэд захирал Ц.Роза: 2026 онд бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөний танилцуулгыг хийв.

Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт санал, тодруулах асуудал байна уу?

Хувьцаа эзэмшигч, Я.Нэргүй: Санал байхгүй, дэмжиж байна.

Дөрөвдүгээр асуудал. ТУЗ-н гишүүдийг томилох.

Хурал даргалагч Я.Нэргүй: ТУЗ-ийн 8 гишүүнийг улируулан сонгохоор оруулж ирж байгаа, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Рэнцэнноровыг нэр дэвшүүлэх асуудлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд санал дэвшүүлсэн. Компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагуудыг бүрэн хангаж байгаа хүн байгаа.

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээний хүрээнд ТУЗ-н гишүүдийг сонгох эрхтэй байх тул ТУЗ-н хурлаас дэвшүүлсэн нэр дэвшигч гишүүдийг ТУЗ-н гишүүдээр томилох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа

эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжин томилов. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт санал, тодруулах асуудал байна уу?

Хувьцаа эзэмшигч, компанийн дэд захирал Ц.Роза: Санал байхгүй, дэмжиж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хуралд оролцсон ТУЗ-ийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн 2026 оны Бизнес төлөвлөгөөг сонсож, цаашид Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахыг даалгасугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Н.Сүндэрьяа
4. Н.Цэцэнхаан
5. Н.Сүлд-Оргил
6. Ж.Ганболд

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор
2. Д.Сэржамц
3. Д.Рэнцэнноров
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Тооллогын комиссын дарга, гишүүд нарт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулж дууссаны дараагаар Хурал даргалагч Я.Нэргүй хурал хаасныг мэдэгдэв. Хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 16:50 цагт хаав.

Тэмдэглэл хөтөлсөн:



С.Батчимэг

ХУРЛЫН ДАРГА:

Я.НЭРГҮЙ